



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 11/137

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2.1, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Зам дагуух ногоон байгууламжийн хашааг засварлах, худалдан авах” ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүн:

Д.Мөнхзаяа

(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

О.Отгонбаяр

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих арга хэмжээ”-ний хүрээнд “Зам дагуух ногоон байгууламжийн хашааг засварлах, худалдан авах” ажилд 12,000,000 (арван

хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

3.“Зам дагуух ногоон байгууламжийн хашааг засварлах, худалдан авах” ажилд зарцуулагдах 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

4.Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг (Ажлын хэсэг)-т, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/75 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА